

Боловсрол судлал**ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧ НАРЫН
СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ЧАДАМЖ БА ТУЛГАМДАЖ БУЙ
АСУУДАЛ****THE MENTALITY OF INTERNAL AFFAIRS STUDENTS
MOTION CAPACITY AND OBJECTIVE ISSUES*****С.Цэрэндолгор***

*ДХИС-ийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Аюулгүй байдлын тэнхимийн багш, хошууч*

Товч утга: Байгууллагын үйл ажиллагаа, хөгжил, соёлыг тодорхойлох үнэт зүйл нь алба хаагчид байдаг. Төрийн тусгай байгууллагад ажиллахаар бэлтгэгдэж буй суралцагч нарын сэтгэл хөдлөл, тэсвэр тэвчээр болон сэтгэл зүйд тулгамдаж буй асуудлыг судлан, тодорхойлох нь тухайн байгууллагын хүний нөөцийн бодлогод эерэгээр нөлөөлөх боломжтой. Учир нь төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагад ажиллахад шаардлагатай сэтгэл зүйг суралцагч байх үед нь төлөвшүүлснээр ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах суурийг олгох юм. Мөн суралцагчдын сэтгэл хөдлөлийн түвшинг тодорхойлсноор сургалтын чанарт дүн шинжилгээ хийж, амжилттай суралцахад нөлөөлөх боломжтойг тодорхойлох юм. Энэхүү судалгаагаар Дотоод хэргийн их сургуулийн суралцагч нарын сэтгэл хөдлөлийн чадамжийг тодорхойлохоор зорисон. Судалгааны үр дүнд суралцагчдын сэтгэл хөдлөлийн түвшин нь тэдний суралцах идэвх, бүтээмж, танин мэдэхүйн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг онолын болон практик үндэслэлээр тайлбарласан болно. Мөн сэтгэл хөдлөлийг зөв удирдах арга зам, сургалтын орчинд үүсэх сэтгэл зүйн нөлөөллийг бууруулах боломжийг судалж, практикт ашиглах зөвлөмжүүдийг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Сэтгэл хөдлөлийн чадамж, сэтгэл хөдлөлийн чадамжийн үндсэн 5 чадвар, өөрийгөө удирдах чадвар, өөрийгөө танин мэдэх чадвар, сэдэлжүүлэлт, бусдыг ойлгох чадвар, нийгмийн чадвар

Abstract: The value of determining the activities, development, and culture of the organization is the employees. Studying and identifying the emotional, resilience, and psychological problems of students preparing to work in special state organizations can positively affect the human resources policy of the organization. This is because developing the psychology necessary for working in special state organizations while they are students will provide a foundation for stable work in the workplace. Also, by determining the emotional level of students, the quality of training can be analyzed and the impact on successful learning can be determined. This study aimed to determine the emotional competence of students at the University of Internal Affairs. The results of the study explain how the emotional level of students affects their learning activity, productivity, and cognitive development on a theoretical and practical basis. It also examines ways to properly manage emotions and the possibility of reducing the psychological impact of the learning environment, and proposes recommendations for practical use.

Key word: Emotional competence, the 5 core skills of emotional competence, self-management, self-awareness, motivation, empathy, and social skills

УДИРТГАЛ

Энэхүү судалгаа нь Дотоод хэргийн их сургуулийн суралцагчдын сэтгэл хөдлөлийн чадамж болон тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон.

Хүн өнгөрсөн зуунд булчин шөрмөсөө ажиллуулдаг байсан бол өнөөдөр тархиа, харин ирээдүйд сэтгэл зүрхээрээ ажилладаг болно. (economist., 2023). Хүн төрөлхтөн ганцаараа агуу зүйлийг бүтээх боломжгүй. Шинжлэх ухааны ололт, амжилт бүхэн олон хүчин зүйлийн нөлөө, тал бүрийн дүгнэлт, санал, сэдэл дээр үндэслэн бий болсон байдаг. Хүний тархи 86 тэрбум орчим нейрон агуулдаг. Эдгээр эсүүд нь тархинд ой санамжийг хадгалах, тархи болон мэдрэлийн системд мэдээлэл, тушаал илгээхэд тусалдаг цахилгаан дохиог ажиллуулдаг. Тархинд мөн олон тэрбум астроцитууд агуулагддаг - од хэлбэртэй эсүүд нь олон тооны урт сунаж тогтсон байдаг бөгөөд тэдгээр нь сая сая мэдрэлийн эсүүдтэй харилцах боломжийг олгодог.

Сэтгэл хөдлөл (эмоци) гэдэг нь хувь хүний дотоод мэдрэмж, орчны өдөөлтөнд үзүүлж буй физиологийн болон сэтгэлзүйн хариу үйлдэл юм. Энэ процессыг тархины тодорхой хэсгүүд удирддаг (Гоулман, 2020).

Түүнчлэн EQ нь шийдвэр гаргах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүчтэй сэтгэл хөдлөлтэй удирдагчид дарамт шахалт дор тайван байдлаа хадгалж чаддаг бөгөөд ингэснээр илүү стратеги, бодлоготой шийдвэр гаргадаг. Үйл ажиллагааны хүрээнд зөрчилдөөнийг үр дүнтэй шийдвэрлэх нь хамгийн чухал. Үйл ажиллагаа хоорондын хамтын ажиллагаа нь ихэвчлэн үл ойлголцолд хүргэдэг ч өндөр EQ-тай удирдагчид харилцан ойлголцол, шударга байдлаар зөрчилдөөнийг зохицуулж, үйл ажиллагааг жигдрүүлдэг. Сэтгэл хөдлөлийн чадамж буюу өөрийгөө таньж, мэдсэн хүмүүсийн манлайлах арга барил нь байгууллагын доторх соёлын өөрчлөлтийг эерэгээр хөгжүүлж чадна. Удирдагчид нь ажилчдын оролцоог нэн тэргүүнд тавьж, инновацийг дэмжин, урт хугацааны амжилтад анхаарлаа хандуулснаар байгууллагын тогтвортой өсөлтийг бий болгож чадна. Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь зөвхөн хувийн шинж чанар биш юм. Энэ нь багийн динамикийг сайжруулах, зөв шийдвэр гаргах, зөрчилдөөнийг шийдвэрлэх, байгууллагынхаа соёлын эерэг өөрчлөлтийг бий болгохыг эрэлхийлж буй үйл ажиллагааны удирдагчдад зориулсан үнэ цэнэтэй ур чадвар юм (Richmond, 2025).

Энэхүү сэдвийн хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль”, “Цагдаа судлал”, “Хил судлал”-ын сургуулийн суралцагч нарын “Сэтгэл хөдлөлийн түвшнийг тодорхойлохыг зорьсон. Уг зорилгын хүрээнд 279 суралцагчаас “Google form”-оор асуулгын арга ашиглан судалгааг авч, дүгнэж үзсэн. Ийнхүү судалгаанд харьцуулалт хийх явцдаа цаашид анхаарвал зохих асуудлуудыг шүүн тунгаахыг хичээсэн.

Сэтгэл хөдлөлийн чадамж, сэтгэл хөдлөлийн удирдлага, хувь хүний хөгжлийн асуудал нь өнөөдрийн боловсролын орчинд онцгой ач холбогдолтой сэдэв болж байна. XXI зуунд зөвхөн академик мэдлэг төдийгүй, хувь хүний сэтгэл хөдлөлийг таних, удирдах, нийгмийн харилцаанд үр дүнтэй оролцох чадвар амжилтын гол хүчин зүйл болж байгаа нь олон улсын судалгаагаар батлагдсан. Даниел Гоулман (Гоулман, 2020) сэтгэл хөдлөлийн чадамж номондоо өөрийгөө таних, удирдах, нийгмийг таних, харилцаагаа удирдах гэх зэрэг сэтгэл хөдлөлийн чадамжийг идэрхийлдэг, ажлын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийг илүү

өргөн хүрээнд дэвшүүлэн тавьсан. Гэсэн хэдий ч энэхүү бүтээлд цэргийн сургуулийн суралцагч нарын сэтгэл хөдлөлийн чадамж, тэдний тэсвэр тэвчээр, сургалтын чанарт хэрхэн нөлөөлөхийг төдийлөн авч үзээгүй тул энэ судалгаагаар эдгээр хүчин зүйлийг нэмж судлах болно.

Судалгаанд сэтгэл хөдлөлийн чадамжийн (EQ) онолын үндэслэлүүдийг ашиглаж, суралцагчдын сэтгэл хөдлөлөө ухамсарлах, удирдах, өөрийгөө зоригжуулах, бусдыг ойлгох, нийгмийн харилцаанд оролцох чадварыг үнэлэхэд чиглэсэн юм. Энэхүү судалгаа нь зөвхөн гурван сургуулийн суралцагчдын сэтгэлзүйн ялгааг тодорхойлоод зогсохгүй, тэдний сэтгэлзүйн хөгжлийг дэмжих, боловсролын орчинд хэрэгжүүлж болох зөвлөмжүүдийг боловсруулахад хувь нэмэр оруулах зорилготой.

Судалгааны хүрээнд дараах асуудлуудыг авч үзнэ:

1. Гурван сургуулийн суралцагчдын сэтгэл хөдлөлийн чадамжийн түвшин ямар байна вэ?
2. Суралцагчдын сэтгэлзүйн ижил төстэй болон ялгаатай талуудыг юу тодорхойлж байна вэ?
3. Сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлэх ямар арга замууд байж болох вэ?

ҮНДСЭН ХЭСЭГ

EQ бол сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшнийг хэмжих нэгж буюу сэтгэл хөдлөлийн чадамж юм. (Гоулман, 2020)

Сэтгэл хөдлөлийн чадамж (Emotional Intelligence, EQ) нь хувь хүний сэтгэлзүйн хөгжил, нийгмийн харилцаанд чухал нөлөөтэй хүчин зүйл юм.

Сэтгэл хөдлөлийн оюун ухаан хэмээх ойлголтыг судлаачид дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

"Сэтгэл хөдлөлийн оюун ухаан гэдэг нь хувь хүн өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг ойлгож, ялгаж таних, тэдгээрийг бодол, үйлдэлдээ зөв ашиглах чадвар юм." /Саловей, Майер/

"EQ гэдэг нь өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг удирдах, зөв зохицуулах, өөрийгөө хөгжүүлэх, нийгэмд үр дүнтэй харилцах чадвар юм." Даниел Гоулман.

Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь хувь хүний дотоод сэтгэлзүйн тэнцвэр, нийгмийн харилцааны үр дүнтэй байдал, өдөр тутмын амьдралдаа бие даан шийдвэр гаргах чадварын цогц илрэл юм. /Реувен Бар-Он/

Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь хүмүүсийн хоорондын болон өөрийн дотоод оюун ухаантай нягт холбоотой." /Говард Гарднер/

Судлаачид EQ-г өөр өөр өнцгөөс тайлбарласан боловч нийтлэг ойлголт нь **EQ нь IQ-ээс гадна хувь хүний амжилтад голлох үүрэг гүйцэтгэдэг** гэсэн дүгнэлтэд хүрдэг.

Сэтгэл хөдлөлийн оюун ухаан гэдэг нь хувь хүний сэтгэл хөдлөлийг танин мэдэх, ойлгох, удирдах, бусдын сэтгэл хөдлөлийг мэдэрч, харилцаандаа үр дүнтэй ашиглах чадварыг хэлнэ. Энэ ойлголт нь сэтгэл судлал, танин мэдэхүйн шинжлэх ухаан, манлайлал, боловсрол зэрэг олон салбарт чухал байр суурь эзэлдэг (Гоулман, 2020).

Даниел Гоулман сэтгэл хөдлөлийн чадамжийг дараах таван үндсэн бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлсон:

- 1. Өөрийн сэтгэл хөдлөлийг ухамсарлах: Хувийн сэтгэл хөдлөлийг таньж мэдэх, ойлгох чадвар.
- 2. Сэтгэл хөдлөлөө удирдах: Сөрөг сэтгэл хөдлөлийг хянах, стрессийг зохицуулах чадвар.
- 3. Өөрийгөө зоригжуулах: Зорилгодоо хүрэхийн тулд урам зориг, тэвчээртэй байх чадвар.
- 4. Эмпати буюу бусдыг ойлгох чадвар: Бусдын мэдрэмж, хэрэгцээг ойлгож, хүндэтгэх.
- 5. Нийгмийн харилцааны чадвар: Хамт олонтой үр дүнтэй харилцах, удирдах, багийн ажилд оролцох чадвар.

Эдгээр чадамж нь суралцагчдын сэтгэлзүйн тэнцвэрт байдал, амжилттай суралцах, нийгмийн орчинд дасан зохицох чадварт чухал нөлөө үзүүлдэг. Судалгааны ерөнхий мэдээлэл:

Хүснэгт 1. Судалгааны ерөнхий мэдээлэл


№	Ерөнхий мэдээлэл		Тайлбар	
			БХИС	ШШГАС
1	Судалгаанд хамрагдаж буй сургуулийн нэр		БХИС	ШШГАС
2	Судалгаанд оролцогчдын тоо		42	57
3	Судалгаанд оролцогчдын хүйс	Эр	87	
		Эм	12	

“Сэтгэл хөдлөлийн чадамж” нь сургуулиудын суралцагчдад ямар түвшинд байгааг тодорхойлоход анхаарлаа хандуулъя.

Хүснэгт №2. Сэтгэл хөдлөлийн түвшнийг тодорхойлох судалгааны харьцуулалт:

Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо	Сул /15-34 оноо/	Дундаж /35-55 оноо/	Хүчтэй /56-75 оноо/
Дотоод хэргийн их сургууль	2	85	12
Нийт	2	85	12

График 1. Сэтгэл хөдлөлийн түвшнийг харьцуулан графикаас харахад:



Сурагчдын дийлэнх олонх сэтгэл хөдлөлийн дундаж түвшинд байна. Дундаж үнэлэгдсэн тохиолдолд:

- ✓ EQ түвшин хэвийн.
- ✓ Хамтран суралцагсадтайгаа ихэвчлэн сайн харилцаатай байдаг боловч зарим тохиолдолд хамтран ажиллах нь төвөгтэй санагддаг.
- ✓ EQ чадвараа хөгжүүлж чадвал илүү амжилтад хүрэх боломжтой юм байна.

Хүчтэй үнэлэгдсэн тохиолдолд:

- ✓ EQ өндөр.
- ✓ Сэтгэл хөдлөлөө удирдан чиглүүлэх гайхалтай чадвар байна.
- ✓ Судлаачдын үзэж байгаагаар EQ өндөр хүмүүс шилдэг удирдагч болох боломжтой байдаг.

- ✓ Энэхүү чадвараа тогтмол хөгжүүлэх шаардлагатай гэж тодорхойлжээ.

Сул үнэлэгдсэн тохиолдолд:

- ✓ EQ түвшин сул.
- ✓ Хөгжүүлэх шаардлагатай.
- ✓ Сэтгэл хөдлөлд хэт автдаг.
- ✓ Сэтгэл санаа хямарна гэж үздэг учраас зөрчилдөөнөөс аль болох зайлсхийдэг.
- ✓ Сэтгэл санаа тухгүй үед удаан хугацаагаар хямардаг.
- ✓ Гэхдээ санаа зоволтгүй. EQ чадварыг бүрэн хөгжүүлэх боломжтой гэжээ.

Дүгнэвэл: Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн суралцагчдын 78% нь сэтгэл хөдлөлийн чадамж дунд, 18% нь сэтгэл хөдлөлийн чадамж хүчтэй, 4% нь сул гэж дүгнэгдсэн байна. Үүнээс үзвэл суралцагчдын EQ чадварыг хөгжүүлэхэд багш нар анхаарал хандуулж, хөгжүүлж чадвал практик байгууллагад ажил үүргээрээ амжилтад хүрэх олон манлайлагчдыг бэлтгэх боломжтой гэж үзэж болно.

Сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлснээр тархинд сөрөг сэтгэл хөдлөлийн мэдрэмжийг бууруулж, бодит байдалд дүгнэлт хийх, зөв шийдвэр гаргах боломжтой. Энэ чадвар нь төрийн тусгай байгууллагад ажиллах боловсон хүчинд зайлшгүй байх ёстой чадвар гэж үзсэн. Учир нь төрийн тусгай алба хаагч нь “Монгол Улсын хууль тогтоомжид тодорхой заагдсан бөгөөд энэ нь **төрийн онцгой чиг үүрэг бүхий байгууллагад** ажиллаж буй, тусгай үүрэг, сахилга, дэг журамтай, олон нийтийн аюулгүй байдал, хууль ёсыг хангахад чиглэсэн ажил эрхэлдэг” тул шийдвэр гаргах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалахад зайлшгүй сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлсэн байх шаардлагатай. Сэтгэл хөдлөлөө удирдах чадварт сул байх нь сэтгэл санаа тогтворгүй, сөрөг сэтгэл хөдлөлд автах, ажлаас халшрах хам шинжид өртөх, аливаа зөрчилдөөнөөс зугтах, зөв шийдвэр гаргаж чадахгүй зэрэг олон сул талыг хувь хүнд бий болгодог.

Иймд суралцагчдын сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг сайжруулан, хүчирхэг EQ-тэй хүн болоход анхаарч ажиллах хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Бидний судалснаар байгууллагын удирдах ажилтан тоонд биш чанарт анхаарч ажилладаг. Удирдах ажлыг манлайлалтай хослуулан, өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, багийг нэн тэргүүнд тавьж, хөгжих боломжоор хангах хандлагатай байх нь чухал юм.

Ажилтан алба хаагчдыг биологийн хувьд судлан, сэтгэл хөдлөл, хувь хүний онцлогийг мэдэрч шийдвэр гаргах, дүгнэлт хийх чадвартай байх.

Сэтгэл хөдлөлийн чадамж буюу өөрийгөө таньж, мэдсэн хүмүүсийн манлайлах арга барил нь байгууллагын доторх соёлын өөрчлөлтийг эерэгээр хөгжүүлж чадна.

Цаашид сонсогч, суралцагч нарын EQ чадамжийг хөгжүүлэх, тэдэнд өөрсдийн давуу талыг олж илрүүлэхэд туслах, бусдын оронд өөрийгөө тавьж үзэх энэрэнгүй сэтгэлийг бий болгоход анхаарч ажиллах нь ирээдүйд байгууллагын хөгжлийг тодорхойлох сэтгэл хөдлөлийн чадамж өндөртэй алба хаагчдыг бий болгох боломжтой гэж дүгнэлээ.

Эх сурвалж

economist., B.-A. a. (2023). Minouche Shafik (مينوش شفيق).

Richmond, T. U. (2025). Manufacturing Operations Leader. Texas:
<https://www.linkedin.com/in/johncaldwelljr/>.

Гоулман, Д. (2020). Сэтгэл хөдлөлийн чадамж. Newyork : BMB.